

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Есөнбулаг сумын 8 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/114/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр
	Утас: 70483413      Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055      Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Аудиторын туслах: Ч.Даваасүрэн Утас: 99559722      Цахим хаяг: <a href="mailto:daavkach@gmail.com">daavkach@gmail.com</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан .....	8
3.1 Ерөнхий зүйл .....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	8
3.4 Материаллаг байдал.....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	10
3.8 Аудитын гол асуудал.....	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт.....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	13

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 82

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Есөнбулаг сумын 8 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Есөнбулаг сумын 8 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

07120098

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>50,081,623.59</b>	<b>58,144,185.27</b>
<b>АВЛАГА</b>	1,452,741.00	1,101,362.68
Ажиллагчидтай холбогдсон авлага	1,452,741.00	1,101,362.68
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	48,628,882.59	57,042,822.59
<b>Түүхий эд материал</b>	15,859,228.96	21,759,228.96
Тусгай зориулалттай материал	15,859,228.96	21,759,228.96
<b>Хангамжийн материал</b>	32,769,653.63	35,283,593.63
Бичиг хэргийн материал	226,000.00	226,000.00
Аж ахуйн материал	10,043,597.00	12,404,597.00
Сэлбэг хэрэгсэл	1,200,000.00	1,200,000.00
Барилгын засварын материал	2,431,000.00	2,431,000.00
Хүнсний материал	1,057,270.00	1,185,210.00
Бусад хангамжийн материал	17,811,786.63	17,836,786.63
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>360,729,026.76</b>	<b>694,774,433.27</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	360,729,026.76	694,774,433.27
<b>Биет хөрөнгө</b>	288,393,293.61	622,608,700.16
Барилга, байгууламж, орон сууц	334,980,417.99	696,111,817.99
Хуримтлагдсан элэгдэл	(84,409,783.08)	(123,799,031.28)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	30,034,356.70	43,579,643.50
Хуримтлагдсан элэгдэл	(18,304,256.65)	(22,563,293.68)
Тавилга, аж ахуйн эд хогшил	40,635,804.20	48,610,515.00
Хуримтлагдсан элэгдэл	(19,360,221.51)	(23,295,050.49)
Бусад үндсэн хөрөнгө	7,259,768.00	7,259,768.00
Хуримтлагдсан элэгдэл	(2,442,792.04)	(3,295,668.88)
<b>Биет бус хөрөнгө</b>	72,335,733.15	72,165,733.11
Програм хангамж	850,000.00	850,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(511,666.85)	(681,666.89)
Бусад биет бус хөрөнгө	71,997,400.00	71,997,400.00
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>410,810,650.35</b>	<b>752,918,618.54</b>
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>410,810,650.35</b>	<b>752,918,618.54</b>
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	410,810,650.35	752,918,618.54
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	71,997,400.00	71,997,400.00
Өмч: - төрийн	71,997,400.00	71,997,400.00
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	296,352,713.48	638,460,681.67
Өмнөх үеийн үр дүн	296,352,713.48	296,352,713.48
Тайлант үеийн үр дүн	-	342,107,968.19
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	42,460,536.87	42,460,536.87
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>410,810,650.35</b>	<b>752,918,618.54</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Гайлантай оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>388,880,909.00</b>	<b>756,961,295.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,933,309.00</b>	<b>365,278,295.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	6,933,309.00	365,278,295.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,933,309.00	365,278,295.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,933,309.00	365,278,295.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан -Үндсэн хөрөнгө		364,524,295.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		754,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>381,947,600.00</b>	<b>391,683,000.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	331,985,000.00	364,983,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	331,985,000.00	364,983,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	45,000,000.00	26,700,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,000,000.00	26,700,000.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>426,017,012.98</b>	<b>414,853,326.81</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>426,017,012.98</b>	<b>414,853,326.81</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	395,836,388.25	399,509,458.37
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	267,598,371.09	267,128,721.19
210101	Үндсэн цалин	254,079,355.09	242,626,758.99
210104	Урамшуулал	13,519,016.00	24,501,962.20
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	31,308,569.03	35,454,828.09
210201	Тэтгэврийн даатгал	20,792,000.21	24,246,901.47
210202	Тэтгэмжийн даатгал	2,014,067.97	2,867,886.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,308,482.37	2,171,754.74
210204	Ажилгүйдлийн даатгал	563,274.95	553,644.58
210205	Эрүүл мэндийн даатгал	5,630,743.53	5,614,640.62
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	22,216,264.90	22,103,160.60
210301	Гэрэл, цахилгаан	20,485,644.90	21,110,740.60
210303	Цэвэр, бохир ус	1,730,620.00	992,420.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,137,282.96	3,593,350.00
210401	Бичиг хэрэг	650,000.00	1,294,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	578,682.96	494,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	436,000.00	256,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,288,600.00	1,548,000.00
2105	<b>Нормативт зардал</b>	17,842,885.00	14,775,410.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	328,000.00	650,000.00
210502	Хоол, хүнс	17,514,885.00	14,125,410.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,818,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	7,818,000.00	1,000,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	544,000.00	888,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	240,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	45,371,015.27	54,565,988.49
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	248,000.00	687,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45,123,015.27	53,878,888.49
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	30,180,624.73	15,343,868.44
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,742,600.00	1,860,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,962,600.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	780,000.00	1,860,000.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	14,783,735.10	1,696,839.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,783,735.10	1,696,839.40
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	9,654,289.63	11,787,029.04
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,654,289.63	11,787,029.04
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(37,136,103.98)</b>	<b>342,107,968.19</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	71,997,400.00	42,460,536.87	296,352,713.48	0.00	410,810,650.35
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	71,997,400.00	42,460,536.87	296,352,713.48	0.00	410,810,650.35
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	71,997,400.00	42,460,536.87	296,352,713.48	0.00	410,810,650.35
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	71,997,400.00	42,460,536.87	296,352,713.48	0.00	410,810,650.35
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	71,997,400.00	42,460,536.87	296,352,713.48	0.00	410,810,650.35
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	342,107,968.19	0.00	342,107,968.19
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	71,997,400.00	42,460,536.87	638,460,681.67	0.00	752,918,618.54

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	381,947,600.00	391,683,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	381,947,600.00	391,683,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	331,985,000.00	364,983,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,000,000.00	26,700,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,000,000.00	26,700,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	381,947,600.00	368,283,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	351,746,975.27	352,939,131.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	266,027,082.41	266,777,342.87
210101	Үндсэн цалин	241,871,632.51	242,275,380.67
210104	Урамшуулал	24,155,449.90	24,501,962.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,443,780.00	35,454,828.09
210201	Тэтгэврийн даатгал	25,616,191.00	24,246,901.47
210202	Тэтгэмжийн даатгал	-	2,867,886.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,087,400.00	2,171,754.74
210204	Ажилгүйдлийн даатгал	521,789.00	553,644.58
210205	Эрүүл мэндийн даатгал	5,218,400.00	5,614,640.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,216,264.90	22,103,160.60
210301	Гэрэл, цахилгаан	20,485,644.90	21,011,630.60
210303	Цэвэр, бохир ус	1,730,620.00	1,091,530.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,130,282.96	4,845,350.00
210401	Бичиг хэрэг	650,000.00	1,294,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	578,682.96	494,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	436,000.00	256,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,197,600.00	2,800,000.00
2105	Нормативт зардал	16,997,565.00	14,903,350.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	328,000.00	650,000.00
210502	Хоол, хүнс	16,489,565.00	14,253,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00	1,380,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	380,000.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	544,000.00	888,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	240,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	388,000.00	6,587,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	388,000.00	6,587,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,200,624.73	15,343,868.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,762,600.00	1,860,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	1,860,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,783,735.10	1,696,839.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,783,735.10	1,696,839.40
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,654,289.63	11,787,029.04
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,654,289.63	11,787,029.04
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	23,400,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	23,400,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	23,400,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	23,400,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	23,400,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(23,400,000.00)

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	391,683,000.00	378,199,131.56
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	391,683,000.00	378,199,131.56
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	389,763,000.00	376,339,131.56
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	274,868,000.00	266,777,342.87
210101	Үндсэн цалин	249,368,000.00	242,275,380.67
210104	Урамшуулал	25,500,000.00	24,501,962.20
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	35,719,000.00	35,454,828.09
210201	Тэтгэврийн даатгал	24,247,000.00	24,246,901.47
210202	Тэтгэмжийн даатгал	2,868,000.00	2,867,886.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,294,000.00	2,171,754.74
210204	Ажилгүйдлийн даатгал	574,000.00	553,644.58
210205	Эрүүл мэндийн даатгал	5,736,000.00	5,614,640.62
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	23,800,000.00	22,103,160.60
210301	Гэрэл, цахилгаан	22,000,000.00	21,011,630.60
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	1,091,530.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,256,000.00	4,845,350.00
210401	Бичиг хэрэг	1,310,000.00	1,294,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	610,000.00	494,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, а	296,000.00	256,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,800,000.00	2,800,000.00
2105	<b>Нормативт зардал</b>	17,859,700.00	14,903,350.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	650,000.00	650,000.00
210502	Хоол, хүнс	17,209,700.00	14,253,350.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	24,780,000.00	24,780,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,880,000.00	11,880,000.00
210602	Тавилга	10,000,000.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	2,900,000.00	2,900,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	888,000.00	888,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	240,000.00	240,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	648,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,592,300.00	6,587,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,592,300.00	6,587,100.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,920,000.00	1,860,000.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,920,000.00	1,860,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,920,000.00	1,860,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	391,683,000.00	378,199,131.56
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	364,983,000.00	353,195,970.96
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	364,983,000.00	353,195,970.96
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	26,700,000.00	25,003,160.60
132001	Орон нутгийн төсвөөс	26,700,000.00	25,003,160.60

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Есөнбулаг сумын 8 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-ний Говь-Алтай аймаг дахь салбарын аудиторын туслах Ч.Даваасүрэн гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Есөнбулаг сумын 8 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 04 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх, хүүхдийг бие бялдрын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх ариун цэвэр эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болгох, хэл яриа сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх хүрээлэн байгаа орчин юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 8 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлого 439.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 6.1 сая төгрөгөөр тооцсон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Есөнбулаг сумын 8 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 83.28 хувиар буюу 342.1 сая төгрөгөөр өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Авлага дансны үлдэгдэл 1.1 сая төгрөг болж 0.3 сая төгрөгөөр буурсан. Авлагын үлдэгдэл нь ХХОАТ-ын авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 57.0 сая төгрөг болж 8.4 сая төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал, аж ахуйн материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 26.9 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 0.8 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 19.3 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 694.7 сая төгрөг болж 334.0 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 23.4 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 3.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, цэцэрлэгийн барилгад их засварын ажил хийгдэж 361.1 сая төгрөгийн өртгийг капиталжуулж, орон нутгийн өмчийн тогтоолоор 5.2 сая төгрөгийн хөрөнгө акталантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 752.9 сая төгрөг болж 342.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 94.7 хувиар буюу 368.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5

дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй. Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 490.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 98.8 сая төгрөгөөр бууруулж, 391.6 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс бага байгаа нь норматив зардал багассантай холбоотой байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 391.6 сая төгрөгийн төсөв баталснаас 364.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 26.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 364.9 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 26.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 378.2 сая төгрөгийг зарцуулж 11.7 сая төгрөгийг улсын төсөвт, 1.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 378.2 сая төгрөг буюу 98.4 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 8.1 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 0.3 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 1.7 сая төгрөгөөр, нормативт зардлыг 2.9 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 0.4 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 445.4 сая төгрөгийн 36 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас 440.1 сая төгрөгийн 35 мэдээллийг ил тод байршуулсанаас 352.7 сая төгрөгийн 24 мэдээлэл хугацаа хоцроосон, 5.3 сая төгрөгийн 1 мэдээлэл байршуулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4.7 сая төгрөгийн төлбөрийн акт, зөрчил арилгах албан шаардлага хүргүүлснийг биелүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн жилийн аудитаар

- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийн чанар, ашиглалтын байдал
- Бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах
- Нягтлан бодох бүртгэлийн дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн шинж чанар, үнэнд дүн шинжилгээ хийх
- Татварын өглөг авлагын тооцоог хянах

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2.2 сая төгрөгт албан шаардлага, төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний талаар албан шаардлага, шилэн дансны хэрэгжилтийн талаар зөвлөмж хүргүүлээ

### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа байхгүй.

### 4.2 Төлбөрийн акт

- ✓ Улирлын үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингаас тооцож 0.1 сая төгрөгийг илүү олгосон нь "Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.
- ✓ Ажилтны амралт, цалин давхардуулан 0.4 сая төгрөгийн олгосон нь "Төсвийн тухай хуулийн 16 дугаар үйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." Есөнбулаг сумын 8-р цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 06 сарын 18-ны А/13 тоот "Ээлжийн амралт олгох тухай" тушаал"-тай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

#### 4.3 Албан шаардлага

- ✓ Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлаагүйгээр 1.2 сая төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалт" ТБОНӨХ-өөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад авто машин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" заалттай нийцэхгүй заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- ✓ Нийгмийн даатгалд 4 сард ажил олгогчоос төлөх шимтгэлийг даатгуулагчийн төрлийг 0.2 сая төгрөгөөр буруу тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- ✓ Жилийн эцсийн тооллогоор 0.7 сая төгрөгийн сэлбэг хэрэгслийг тооллогын комисс дутуу тоолсон нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө, 20.2.6-т "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- ✓ Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлээгүй, давтан гаргасан нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8-т "өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх", 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах" заалттай заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа сахилгын хариуцлага тооцуулах хариуцлага тооцох албан шаардлагыг томилдог албан тушаалтанд хүргүүлээ.
- ✓ Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь: Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын 1.1-д" Үндсэн үйл ажиллагаатай холбоотой , зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсвөөс , арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож , урсгал, болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөж хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой**

1.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд Шилэн дансны нэгдсэн цахим системд 352.7 сая төгрөгийн 24 мэдээлэл хугацаа хоцроосон, 5.3 сая төгрөгийн 1 мэдээлэл байршуулаагүй, хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ, 6 дугаар зүйлийн 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр " гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

**1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Есөнбулаг сумын 8 дугаар цэцэрлэг	7	2.7	-	-	2	0.5	5	2.2	1	-

/сая төгрөгөөр/